

ХҮЙСИЙН ТЭГШ ЭРХ ТӨВ ТББ

(2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН)

ТЭРГҮҮН

Г.ГАНБАЯСГАХ

Хэрэгжүүлэгч байгууллага: Хүйсийн тэгш эрх төв ТББ

Тус төв нь бэлгийн харилцааны хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэг, хүн худалдаалах гэмт хэргийн өртөгсөд болон хохирогсодод хууль зүйн болон сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон нийгэм дэх хүйсийн тэгш эрхийн харилцааг бүрдүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагаа явуулдаг нийгэмд үйлчилдэг, ашгийн бус төрийн бус байгууллага юм.

Сүүлийн жилүүдэд хохирогч охидын насны бүлэг буурч байгаа нь эмзэглэл төрүүлж байна. Гэмт хэрэгтэнүүд хохирогчдыг цагдаа, хуулийн байгууллагад танилтай гэж айлган сүрдүүлж, зодож байнгын хяналтан доороо байлгадаг бөгөөд ихэвчлэн бөөнөөрөө хөлсний байруудаар амьдарч, гэр оронгүй өсвөр насны хүүхэд залуучуудыг гэмт хэрэгтээ татан оролцуулдаг. Өсвөр насны ар гэрийн хараа хяналтгүй хөвгүүдэд хоол унд орох байраар ханган хохирогч охидыг харгалзуулах, үйлчлүүлэгч олуулах, машин бариулах зэргээр ашиглаж, гэмт үйлдэлдээ татан оруулдаг.

Эрүүл мэндийн үйлчилгээ:

ХХГХ-н хохирогч болсон хохирогч үйлчлүүлэгчдийг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулсан. Өмнөх жилүүдтэй харьцуулахад БЗДХ-аас тэмбүүгийн өвчлөл нэмэгдсэн. Тухайлбал:

- БЗДХ(тэмбүү)
- Шээс бэлгийн замаар дамжих халдвараас үүсэлтэй бөөрний үрэвсэл
- Уушигны хатгалгаа, дотор бусад эрхэтний өвчлөл
- Сэтгэцийн өөрчлөлт
- Бэртэл гэмтэл, дотуур бэртэл
- Шамбарам буюу цагаан мах эргэх
- Эмэгтэйчүүдийн (сав, өндгөвчний үрэвсэл, киста гэх мэт) өвчин гэсэн өвчлөлүүд байсан.

Мөн бэлгийн бойжилт нь бүрэн гүйцээгүй үйлчлүүлэгч охидын 60% нь тэмбүү,заг хүйтэн, трихомнадаар хавсарсан байдлаар өвчилсөн байгаа нь тэдний нөхөн үржихүйн эрүүл мэндэд хохирол учруулж байна. Тэмбүү өвчнийг эмнэлгийн нөхцөлд эмчлүүлж байгаа ч цусан дахь титр өндөр гардаг учраас хоол үйлдвэрлэл, хүүхдийн байгууллага, үйлчилгээний байгууллагад ажиллах боломжгүй, мөн хүүхэд нь төрөлхийн тэмбүүтэй төрж байгаа сөрөг талууд их байна.

Тайлангийн хугацаанд нийт нийт давхардсан тоогоор 40 үйлчлүүлэгчид өвлийн нэг удаагийн иж бүрэн хувцас, хавар намрын хувцас, дотуур хувцас олгох үйлчилгээг үзүүлсэн. Ихэнхдээ ядуу гэр бүлийн хүүхдүүд, мөн буёдын эрхшээлд байх хугацаанд нь тэдэнд зөвхөн бусдын сонирхолыг татах “ажлын хувцас” авч өгдөг боловч зугатаахдаа өмссөн хувцаснаасаа өөр юу ч үгүй болсон байдаг. Тиймээс улирлаас хамаарсан нэг ээлжийн солих хувцас, дотуур хувцас болон ариун цэврийн хэрэгсэлээр бүрэн хангасан. Гэвч өвлийн улиралд ирж буй хохирогчдод хувцасны зардал харьцангуй өндөр тусдаг. Ихэнхдээ гэрээсээ гарахдаа өмсөж байсан нимгэн пүүз нимгэн хувцастай байдаг тул дулаан байхад шаардалгатай бүх хувцасыг авч өгөх шаардалга тулгардаг.

Мэргэжлийн сургалт:

Үйлчлүүлэгч хүүхдүүдийг өөрсдийн сонирхолын дагуу мэргэжлийн сургалтын төвтэй гэрээ байгуулан суралцуулж 7-н хүүхдийг үсчин, гоо сайханч, оёдол эсгүүр, маникюр, жолооны дамжаанд сургаж амжилттай төгсгөлөө.




Өмгөөллийн туслалцаа :

Бэлгийн хүчирхийлэл хүчингийн гэмт хэрэг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын хохирсон эрхийг сэргээлгэхээр хуулийн байгууллагад хохирогчийг мэргэшсэн өмгөөлөгчөөр хамгаалуулан оролцуулдаг. Манай улсад энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт хагалтгүй, ихэвчлэн хэрэг шалгагдах явцад дундаасаа гомдолгүй гэж тохиролцох, эсвэл хохирогчийг буруутгах хандлага бүх шатандаа байсаар байна. Тиймээс тэдэнд мэргэшсэн өмгөөлөгчийн туслалцаа нэн чухал байдаг. Тайлангийн хугацаанд нийт 6 үйлчлүүлэгчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн байна.

Бусад үйл ажиллагаа:

Нийслэлийн цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийлэлтэй тэмцэх алба, Эрүүгийн цагдаагийн газрын ЗБГХТХ-тэй хамтран уулзалт зохион байгууллаа. Уулзалтаар хохирогч болж байгаа насанд хүрээгүй болон залуу охид эмэгтэйчүүдийн талаарх өнөөгийн байдал, бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэж буй арга зам, шалгагдаж буй хэргүүд хохирогчдын талаар ярилцаж цаашид хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцлоо. Мөн хамгаалах байрны талаар Нийслэлийн цагдаагийн газрын харъяа түр хамгаалах байрны ахлах мэргэжилтэн Сэржмядаг, Өмгөөлөгч Бүдханд, мэдээлэл сурталчилгааны ажилтан Ариунтуяа ХТЭТ-ийн ажилтанууд хамтарсан уулзалт хийлээ. Цаашид хохирогчийн удаан хугацааны хамгаалалтыг хэрхэн хийх талаар ярилцаж, ЦЕГ-н дэргэдэх Гэрч хохирогчийн газарт хүсэлт тавьж хандахаар боллоо. Насанд хүрээгүй хүчингийн гэмт хэргийн хохирогч хүүхдүүд болон тэдний ар гэрийнхэн, өмгөөлөгчтэй

хамтарсан уулзалтыг зохион байгуулж шүүх хуралд охидыг сэтгэлзүйг бэлтгэх ажил хийлээ.



Бусад байгууллагатай хамтран ажилласан:

ЭМЯ-ны захиалгаар “Хүчирхийллээс үүдэлтэй охид залуу эмэгтэйчүүдийн БЗДХ, ХДХВ-ийн халдварт өртөлтийн байдлыг үнэлэх” судалгаанд Гүнж төв, Хөөрхөн зүрхнүүдийн аян, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Цөлийн сарнай зэрэг байгууллагуудтай хамтран ажилласан. Судалгааны арга зүйд нэгдсэн байдлаар мэргэших зорилгоор судлаачдад зориулсан сургалтыг явуулж, хүчирхийллийн асуудлаар судалгаа авахад зориулсан Ёс зүйн гарын авлагыг боловсруулж тараасан. Ингэснээр цаашид энэ төрлийн судалгаа авахад хамтран ажиллах, хохирогчийн нэр төрийг хамгаалах чиглэлээр адил түвшиний мэдээлэлтэй болох боломж бүрдэж байгаа юм.

Мөн FDJ-ээс зохин байгуулсан өсвөр насны хүүхдийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаанд төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтайгаа хамтран Налайх, Багахангай дүүргийн 50 хүүхдээс судалгаа авсан ба 2017 оны 8 сард судалгааны тайлангийн хураангуйг боловсруулан хүлээлгэн өглөө.

АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэйгээр “Хууль сахиулах байгууллагын алба хаагчид, прокурор, шүүгч, хил хамгаалах болон гадаадын иргэн харьяатын албан хаагчдын хохирогчтой төвтэй аргачлалыг хэрэглэх чадавхийг үнэлэх” судалгааны ажилд Цөлийн сарнай ТББ, Хөөрхөн зүрхнүүдийн аян, Өсвөр үеийнхэний хөгжлийн төвийн мэргэжлийн нийгмийн ажилтан нарыг судалгааны багт хамруулан ажилласан.

Сургалт:

Баянзүрх, СХД-ийн ерөнхий боловсролын сургуулиуд болон Баянзүрх, Сонгино хайрхан дүүрэгт орших Халамжийн төвийн 1600 гаруй хүүхдүүдэд ХХГХ-ийн талаарх анхан шатны мэдээлэл өгөх, урьдчилан сэргийлэх сургалт явууллаа.

